



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/639

Булган сум

### Төлөвлөгөө баталж, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.3.1, 1.6.1.1, 1.6.1.6, 1.6.3.1 дэх заалт, Хурлын 2023 оны XVII дугаар Хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 17/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/593 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг тодотгон батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоо эрчимжүүлэх төлөвлөгөөг 1 дүгээр, төлөвлөгөөний дагуу Улсын Гуравдугаар Төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарыг ажиллахад шаардлагатай төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Харьяалалын хүн амыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд бүрэн хамруулах, даатгалгүй иргэдийг даатгалд хамруулж, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Арга хэмжээг чанартай, хурдан шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

4. Дээрх арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 700000 (долоон зуун мянга) төгрөгийг “Эрүүл мэнд” хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дугаар сарын  
07 өдрийн 4/63 дугаар захирамжийн 01 дугаар хавсралт

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ, ОНОШЛОГООГ  
ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	Иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдалтын судалгаа мэдээллийг тогтмол шинэчилж ажиллах	9-12 сард	Иргэдийн хамрагдалтын мэдээллийг насны бүлэг, харьяалал, ажил	Сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүд	Багийн Засаг дарга
2	Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийн судалгааг нийгмийн бүлгээр гаргаж, хамрагдлуулах арга хэмжээг зохион байгуулах	9-10 сард	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн тоо нэмэгдэнэ	ЭМДХ	ХХҮГ
3	2-5, 6-17 насны хүүхдүүдийн эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтыг харьяалах сургууль, цэцэрлэгээр гарган хамрагдалтыг нэмэгдүүлэх	9-11 сард	2-17 насны хүүхдийн үзлэгийн хамрагдалт 90 хувьд хүрсэн байна.	ЭМГ, АНЭ, Өрх, сумын ЭМТ	Боловсрол, шинжлэх ухааны газар, ЕБС, СӨБ
4	18-34 насны залуучуудыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт хамруулах арга хэмжээг зохион байгуулах	10 сард	18-34 насны залуучуудын хамрагдалтыг 25 хувьд хүрсэн байна.	Аймгийн Залуучуудын зөвлөл	НЭ, өрхийн ЭМТ-үүд
5	61-ээс дээш насны ахмадуудыг эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ оношлогоонд хамруулах ажлыг зохион байгуулах	10 сард	61-ээс дээш насны ахмадуудын хамрагдалтыг 30 хувьд хүрсэн байна.	ЭМГ НЭ	ХХҮГ
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ оношлогоонд насны бүлгээр хамруулах арга хэмжээг зохион байгуулах	11 сард	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлсэн байна.	ХХҮГ	ЭМГ НЭ
7	Эрт илрүүлгийг үндсэн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр үйлчлүүлэгчид чирэгдэлгүй үзүүлэхээр зохион байгуулах хүний нөөцийг бүрдүүлэн дуран болон дүгнэлтийн эмч, /зүрх судасны эмч/-ийн тоог нэмэгдүүлэхэд УГТЭ-тэй хамтран ажиллах	9-10 сард	Шаардлагатай эмч, эмнэлгийн мэргэжилтэнг ажиллуулан хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	ЭМГ	УГТЭ
8	Төрийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын эрт илрүүлэгт хамрагдалтын	9-11 сард	Төрийн байгууллагуудын албан хаагчдыг хамрагдалтыг 70 хувиас дээш хүргэнэ.	АЗДТГ-ын НБХ	ЭМГ

	судалгааг гаргаж, хамрагдаагүй албан хаагчдыг нэн даруй хамруулах арга хэмжээг зохион байгуулах				
9	Зорилтот өрхийн (ХБИ, өнчин, архины хамааралтай, бичиг баримтгүй, өрх толгойлсон эхчүүд, ахмад настан, хүнсний талон, амжиргаа дэмжих зөвлөлөөс сонгогдсон өрх)-ийн судалгааг гаргаж, сургалт сурталчилгаа, ЭМДаатгал, эрт илрүүлэгт хамруулах	9-11 сард	Зорилтот өрхийн эрүүл мэндийн даатгал, эрт илрүүлэгт хамрагдалтыг нэмэгдүүлсэн байна.	ЭМГ	ХХҮГ
10	Иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт хамрагдахыг уриалгыг Аймгийн Засаг дарга гарган түгээх	9-10 сард	Иргэд, залуучуудад чиглэсэн уриалгыг түгээсэн байна.	АЗДТГ-ын хэвлэл мэдээллийн алба	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага
11	Залуучуудыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт хамрагдахыг уриалгыг бэлтгэн сурталчилах				
12	Хүүхдийн шүд цоорох өвчнийг эмчлэх ажлыг эрчимжүүлж, шүдний кабинеттай сумын эрүүл мэндийн төвд эмч хуваарилан ажиллуулах	9-10 сар	Шүд цоорох өвчний эдгэрэлтийн хувь нэмэгдсэн байна.	ЭМГ, АНЭ	Сумдын ЭМТ-үүд
13	МСҮТ-ийн оюутнуудын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэх судалгааг гарган эрт илрүүлэгт хамруулах ажлыг эрчимжүүлэх	9-10 сард	Оюутнуудын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалтыг 70 хувьд хүргэнэ	ЭМГ, АНЭ	БШУГ, МСҮТ
14	Залуучуудад зонхилон тохиолдож байгаа өвчлөл /БЗДХ, архи, тамхинаас шалтгаалсан өвчлөл/-ийн талаар 3 жилийн үзүүлэлт, судалгаа гаргаж сургалт сурталчилгаа зохион байгуулах	9-11 сард	Судалгааны үр дүнд суурилсан төлөвлөлтийг гарган хэрэгжүүлэх	ЭМГ	АНЭ
15	Эрт илрүүлэг үзлэг, оношлогооны санхүүжилтийн байдалд	9 сард	Эрт илрүүлгийн үзлэгийн санхүүжилтийг	ЭМГ	АНЭ, өрх сумын ЭМТ-үүд

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: НБХ-ИЙН ЭМБЗ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

/М.СОЛОНГО/

Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дугаар сарын  
07 өдрийн 169 дугаар захирамжийн 02 дугаар хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ "ХҮРЧ ҮЙЛЧИЛБЭ" НЭГДСЭН  
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
1.	Улсын Гуравдугаар төв эмнэлгийн эмч нарын байрны зардал	Хүн.Хоног	2 хүн 7 хоног	50000	700 000
	Дүн				700,000